



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 5 дугаар
сарын 08 өдөр

Дугаар

А-89

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Нэг. Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Нийслэлийн яаралтай түргэн тусламжийн үйлчилгээнд онц шаардлагатай байгаа богино долгионы радио холбооны хэрэгсэл авах хөрөнгийн эх үүсвэрийг 1998 оны хөрөнгө оруулалтын зардлаас гаргаж санхүүжүүлэхийг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (н.Төрбиш), Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (н.Бат)-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ -

Ж.НАРАНЦАЦРАЛТ



Нийслэлийн Засаг даргын 1997
оны 7-8-д тоот захирамжийн
хавиралт.

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг: Нийтлэг үндэслэл

1. Нийслэлийн түргэн тусламжийн төв/цаашид "төв" гэнэ/ нь нийслэл хотын хүн амд төрөлжсөн нарийн мэргэжлийн яаралтай түргэн тусламжийг нарийн мэргэжлийн бригад, амбулаторийн хэлбэрээр үзүүлэх /насанд хүрэгчдэд/ үйлчилгээ болон эмнэлгийн яаралтай тусламжийн мэдээ мэдээллийг нэгтгэн зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж хэрэгжүүлэх үүрэг бүхий эмнэлгийн байгууллага мөн.

2. Тус төв нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, засгийн газрын тогтоол, байгууллагын эрхийн акт болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3. Төвийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын даргын томилсон захирал удирдан хотын хөдөлмөрчдөд эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай үзүүлэх ажлыг Нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцан, ажлаа тайлагнана.

4. Төвд захирлын зөвлөл ажиллах бөгөөд зөвлөлийн гишүүд, зөвлөлийн ажиллах журмыг төвийн захирал батална.

5. Төв нь эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээг нутаг дэвсгэрийн иргэдэд ойртуулах зорилгоор нийслэлийн 6 дүүргэд хүүхдийн түргэн тусламжийн салбар үйлчилгээг зохион байгуулан ажиллуулж, үйлчилгээний мэдээ мэдээллийг хүлээн авч, мэргэжлийн удирдлагаар хангана.

6. Төвийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу Нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

7. Төвийн захирал нь хагас, бүтэн жилд хамт олны өмнө үйл ажиллагааныхаа тухай тайлан тавьж байна.

8.Төвийн захирал эрх хэмжээний дагуу тушаал гаргаж,биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулна.

9.Төв нь 24 цагийн үйлчилгээтэй яаралтай тусламжийн амбулатори, эмийн сантай,захиргаа аж ахуйн няравтай байх бөгөөд эмнэлэг-үйлчилгээ эрхэлсэн дэд захиралтай байж болно.

10.Төв нь албан бичгийн хэвлэмэл хуудас,тэмдэг хэрэглэнэ.

Хоёр: Төвийн үүрэг

Нийслэлийн түргэн тусламжийн төв нь дор дурьдсан үүрэг хүлээнэ.Үүнд:

а/Нийслэл хотын нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эмнэлгийн түргэн тусламжийн албаны үйл ажиллагааг оновчтой, шуурхай зохион байгуулах,;

б/Түргэн тусламжийн үйлчилгээг чирэгдэлгүй,хөнгөн шуурхай үзүүлэхийн зэрэгцээ иргэдийн тавьсан санал, хүсэлтийг хүлээн авч үйл ажиллагаандаа тусгаж ажиллах,;

в/Түргэн тусламжийн үйлчилгээнд эмч,эмнэлгийн дунд мэргэжилтнүүдийг шаардагдах эм,био бэлдмэл,эмнэлгийн багаж,аппарат хэрэгслэлээр тогтмол хангаж байх,;

г/Төв нь эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах,тэдний мэргэжлийн ур чадварыг системтэй дээшлүүлэх,цалин хөлс,нийгмийн асуудлыг шийдвэрлэх,;

д/Түргэн тусламжийн дуудлага хүлээн авах үйлчилгээг богино долгионы радио холбооны хэрэгслэлээр найдвартай хангах,зохистой ашиглах,;

е/"Нийслэлийн түргэн тусламж ХХК"-наас төлбөртэй авч байгаа түргэн тусламжийн автомашинуудын явалт,жолооч нарын цаг ашиглалтанд байнгын хяналт тавьж,жолооч нарын дагалдах хуудсыг эмч нар хөтлөх,;

ё/Ажиллагсадыг хөдөлмөрлөх боломж,нөхцөлөөр хангаж,хөдөлмөр хамгаалал,аюулгүй ажиллагаа болон эрүүл ахуйн шаардлагыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх,;

ж/Түргэн тусламжийн мэдээ тайланг хотын хэмжээнд нэгтгэн, тогтоосон хугацаанд гаргах, холбогдох байгууллагад өгөх,;

з/Туслах аж ахуй эрхлэх,төлбөрт үйлчилгээ явуулан ашгийг нь ажилчдын нийгмийн асуудалд зарцуулах.

Гурав: Төвийн эрх

а/ Монгол улсад мөрдөгдөж буй хууль,эрх зүйн хэмжээнд бие даасан үйл ажиллагаа явуулж,батлагдсан төсөвтөө багтааж байгууллагын бүтэц,зохион байгуулалтыг боловсронгуй болгох,орон тоо,төсөв,хөрөнгийг захиран зарцуулах,;

б/ Төвийн болон эмнэлгийн тусламжийн үйл ажиллагаатай холбогдон гарсан хууль,тогтоомжийг биелүүлэх, биелэлтийг мэдээлэх ажлыг зохион байгуулах,;

в/ Эмнэлэг үйлчилгээний ажилд шинэ санаачилга,тэргүүний арга барил нэвтрүүлсэн тэргүүний эмч,ажилчдыг төр засгийн дээд шагналд тодорхойлох, байгууллагын зүгээс шагнаж урамшуулах,;

г/ Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр гадаад дотоодын холбогдох байгууллагуудтай гэрээ,хэлцэл байгуулан хамтран ажиллаж гадаад харилцааг хөгжүүлэх,;

д/ Эмнэлэг,үйлчилгээний талаар ажлын хариуцлага алдсан,хөдөлмөрийн сахилгыг ноцтойгоор зөрчсөн хүмүүст зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх,;

Дөрөв: Санхүүгийн үйл ажиллагаа

а/ Төвийн хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө, улсын төсөв бусад санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ./төлбөрт үйлчилгээний болон туслах аж ахуйн орлого/

б/ Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг оновчтой ашиглаж зарцуулах, санхүүгийн анхан шатны бүртгэл тооцоог бүрэн хариуцна.

в/ Нийслэлийн түргэн тусламжийн үйлчилгээтэй холбогдож гарах зардлыг Нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.

г/ Төв нь туслах аж ахуй эрхлэх зэргээр санаачлагатай ажиллаж нэмэгдэл үйлдвэрлэл үйлчилгээ явуулж,олсон орлогыг ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон байгууллагаа тохижуулах бусад соёл хүмүүжлийн ажилд зарцуулна.